



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 273

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

Нэгжийн дарга нарын зөвлөлийн хурлын 2005 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г үндэслэн ТУШААХ нь: *Соёлын ... Оны 6 сарын 14-ны өдрийн тушаалаар хяналттай*

1.Цогбадрах овогтой Хишигбаярыг АНУ-ын ~~Үндэсний~~ Луйс их сургуулийн магистрантурт боловсрол судлалын чиглэлээр, Мөнхжин овогтой Анараг Япон Улсын Киотогийн их сургуулийн магистрантурт сэтгэл судлалын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2.Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН

*Хишигбаяр 2005 оны 8 сарын 11-ний өдөр
Мөнхжин 2005 оны 8 сарын 11-ний өдөр
Тушаалын дагуу
Улаанбаатар 2005 оны 8 сарын 11-ний өдөр*